



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ




ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СЭРЖАЛТ, ҮНДЭГЭЭ, СУБДУГААНЫ

ИНСТИТУТ



# ХӨДӨЛМӨРИЙН

## ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



2024 ОНЫ III УЛИРАЛ

Улаанбаатар хот

Тойм бэлтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ,  
судалгааны институт,  
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Нарны зам, 55-р байр 2 давхарт 3 тоот  
Утас: (+976) 77121286  
Вэб хуудас: [www.institute.gov.mn](http://www.institute.gov.mn)



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2024 оны III улирал

Улаанбаатар хот

АГУУЛГА	
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	3
ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	6
Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд .....	6
Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд.....	15
Сарын дундаж цалингийн үзүүлэлтүүд .....	20
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	23
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ.....	23
Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадад ажиллах хүч зуучлах .....	27
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа.....	28
ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА 2024..	32
Судалгааны танилцуулга, зохион байгуулалт .....	32
Судалгааны хураангуй.....	32
Судалгааны зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт.....	33
Ахмад настай иргэдийн хөдөлмөр эрхлэлт.....	33
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт .....	34
Залуучуудын /15-34 нас/ хөдөлмөр эрхлэлт .....	34

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн.....	7
Хүснэгт 2. Ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн .....	11
Хүснэгт 3. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллага, даатгуулагч, улирлаар .....	15
Хүснэгт 4. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн тоо, төрөл, улирлаар....	17
Хүснэгт 5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр .....	19
Хүснэгт 6. Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг .....	20
Хүснэгт 7. Ажиллагчдын сарын дундаж цалин, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр, мянган төгрөг.....	21
Хүснэгт 8. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар .....	23
Хүснэгт 9. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн, улирлаар .....	25
Хүснэгт 10. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд.....	26

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, мянган хүн, 2024 оны III улирал .....	6
Зураг 2. Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн .....	7
Зураг 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн .....	8
Зураг 4. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбар, өмнөх оны мөн үеэс, мянган хүн.....	9
Зураг 5. Ажиллагчдын тооны өөрчлөлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 3 салбараар, хүйсээр, өмнөх оны мөн үеэс, мянган хүн .....	9
Зураг 6. Ажиллагчдын тоо, байршлаар, бүсээр .....	10
Зураг 7. Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс, мянган хүн .....	11
Зураг 8. Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, хувиар .....	12
Зураг 9. Хөдөлмөрийн насны хүн ам (15+), хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувь, улирлаар.....	12
Зураг 10. Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин.....	13
Зураг 11. Даатгуулагчийн тоо, төрөл, улирлаар .....	16
Зураг 12. Сайн дураар даатгуулсан малчдын тоо, мянган хүнээр, улирлаар.....	16
Зураг 13. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд, төрлөөр, хувиар .....	17
Зураг 14. Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэдийн тоо, төрлөөр.....	18
Зураг 15. ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд, төрлөөр, хувиар ..	18
Зураг 16. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, улирлаар .....	19
Зураг 17. Дундаж болон медиан цалин, мянган төгрөг, улирлаар.....	20
Зураг 18. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар.....	24
Зураг 19. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар .....	24
Зураг 20. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, хамгийн их 6 улсаар, дүнд эзлэх хувиар .....	27
Зураг 21. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд.....	28
Зураг 22. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, сая төгрөг, 2024 оны III улирлын байдлаар .....	29
Зураг 23. Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны III улирлын байдлаар .....	29
Зураг 24. Санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, .....	30

Зураг 25. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, 2024 оны III улирлын байдлаар .....	31
Зураг 26. Түр ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны III улирлын байдлаар .....	31
Зураг 27. Ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийн ангилал /хувь/ .....	33
Зураг 28. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн бэрхшээлийн төрөл /хувь/ .....	34
Зураг 29. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, ангилалаар / хувь/ .....	34
Зураг 30. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр эрхлэлтийн ангилал /хувь/ .....	34

# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2024 ОНЫ III УЛИРАЛ

2024 оны III улирлын байдлаар арван тав, түүнээс дээш насны хүн амын **1 448.4** мянга (63.0 хувь) нь ажиллах хүч, **849.6** мянга (37.0 хувь) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

## АЖИЛЛАХ ХҮЧ



**1 448.4** МЯНГА



## АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ



**849.6** МЯНГА



## АЖИЛЛАГЧДЫН ТОО, мянган хүн

2023 III **54.8%**

**45.2%**

**1 326.2**

2024 III **54.5%**

**45.5%**

**1 360.3**

**2.6%**  
Өмнөх оны мөн үеэс

## ХАМГИЙН ИХ АЖИЛЛАГЧИДАЙ 3 САЛБАР



**332.8** мянга (24.5%)

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй,  
загас барилт, ан агнуур

**60.2%**  
200.3 мянга



**39.8%**  
132.4 мянга



**187.2** мянга (13.8%)

Бөөний болон жижиглэн худалдаа,  
машин, мотоциклийн завсар, үйлчилгээ

**41.6%**  
78.0 мянга



**58.4%**  
109.2 мянга



**129.1** мянга (9.5%)

Боловсрол

**22.3%**  
28.8 мянга



**77.7%**  
100.3 мянга

## АЖИЛГҮЙ ИРГЭД

2023 III **58.5%**

**41.5%**

**73.9** мянга

2024 III **59.4%**

**40.6%**

**88.1** мянга

**19.2%**  
Өмнөх оны мөн үеэс


Мэдээллийн эх үүсвэр: [www.i212.mn](http://www.i212.mn)

## Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд

Үндэсний статистикийн хорооны Ажиллах хүчний судалгааны 2024 оны III улирлын дүнгээс харахад арван тав, түүнээс дээш насны хүн 2,298.0 мянга, үүнээс 1,448.4 мянга (63.0 хувь) нь ажиллах хүч, 849.6 мянга (37.0 хувь) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Хөдөлмөрийн насны хүн ам өмнөх оны мөн үеэс 25.5 мянга буюу 1.1 хувиар, өмнөх улирлаас 10.3 мянга буюу 0.01 хувиар өссөн байна.

Нийт ажиллах хүчний 54.7 хувь нь эрэгтэйчүүд, 45.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амын 36.3 хувь нь эрэгтэйчүүд, 63.7 хувь эмэгтэйчүүд байна.

Зураг 1. Ажиллах хүч, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо, мянган хүн, 2024 оны III улирал



Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо

Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 48.2 мянгаар, өмнөх улирлаас 19.0 мянгаар өссөн байна.

Ажиллах хүчний 1,360.3 мянга (93.9 хувь) нь ажиллагчид, 88.1 мянга (6.1 хувь) нь ажилгүйчүүд байна. Ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 34.1 мянгаар (2.6 хувь), өмнөх улирлаас 13.2 мянгаар (1.0 хувь) өссөн бол ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 14.2 мянгаар (19.2 хувь), өмнөх улирлаас 5.8 мянгаар (7.0 хувь) өссөн байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үеэс 22.7 мянга буюу 2.6 хувиар, боломжит ажиллах хүч 23.0 мянга буюу 52.8 хувиар буурсан бол бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам 0.3 мянга буюу 0.03 хувиар өссөн байна.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байгаа хөдөлмөрийн насны хүн ам 2024 оны III улирлын байдлаар улсын хэмжээнд 110.3 мянга болж өмнөх оны мөн үеэс 14.4 мянгаар (11.6 хувь), өмнөх улирлаас 7.0 мянгаар (5.9 хувь) буурсан байна. Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бүтцээр нь авч үзвэл, 88.1 мянга (79.8 хувь) нь ажилгүй хүн, 20.6 мянга (18.6 хувь) нь боломжит ажиллах хүч, 1.7 мянга (1.6 хувь) нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч байна.

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч өмнөх оны мөн үеэс 76.5 хувиар, өмнөх улирлаас 76.2 хувиар буурсан байна.



**Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн**

Үзүүлэлт	2023				2024			Өөрчлөлт	
	I	II	III	IV	I	II	III	он	улирал
Ажиллах хүч	1,341.0	1,355.3	1,400.1	1,375.6	1,404.4	1,429.4	1,448.4	48.2	19.0
Үүнээс: эмэгтэй	621.0	619.6	630.2	624.0	642.7	648.6	655.4	25.2	6.8
Ажиллагчид	1,253.9	1,279.1	1,326.2	1,322.2	1,332.6	1,347.1	1,360.3	34.1	13.2
Үүнээс: эмэгтэй	587.8	590.0	599.5	605.2	612.4	613.9	619.7	20.2	5.8
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	6.2	7.0	7.3	6.3	9.5	7.2	1.7	-5.6	-5.5
Үүнээс: эмэгтэй	2.9	5.3	5.1	3.7	5.9	4.5	1.3	-3.8	-3.2
Ажилгүй хүн	87.2	76.2	73.9	53.3	71.8	82.3	88.1	14.2	5.8
Үүнээс: эмэгтэй	33.2	29.6	30.7	18.9	30.3	34.7	35.7	5.0	1.0
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	931	917.2	872.4	896.9	893.7	868.5	849.6	-22.8	-18.9
Үүнээс: эмэгтэй	563.1	562.1	562.2	567.8	547.0	541.4	541.3	-20.9	-0.1
Боломжит ажиллах хүч	32.4	28.0	43.6	53.3	36.3	27.8	20.6	-23.0	-7.3
Үүнээс: эмэгтэй	16.5	15.4	30.2	27.7	16.1	13.8	8.6	-21.6	-5.2
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	898.6	889.1	828.8	843.5	857.4	840.6	829.1	0.3	-11.6
Үүнээс: эмэгтэй	546.6	546.7	532.0	540.0	530.9	527.6	532.7	0.7	5.1
Хөдөлмөрийн дутуу ашиглалт	125.8	111.2	124.7	112.9	117.6	117.3	110.3	-14.4	-7.0
Үүнээс: эмэгтэй	52.6	50.3	66.0	50.3	52.2	53.0	45.7	-20.3	-7.3

Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын тоо 2024 оны III улиралд 1,360.3 мянга болж өмнөх оны мөн үеэс 34.1 мянгаар, өмнөх улирлаас 13.2 мянгаар өссөн байна.

**Зураг 2. Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн**

**Ажиллагчид**




**1 332.6 мянга**

**Ажилгүй хүн**



**71.8 мянга**



Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо

2024 оны III улиралд ажил хөдөлмөр эрхэлж байгаа 100 хүн тутмын 47 нь (47.7 хувь) хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ, боловсролын салбарт ажиллаж байна. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар нь хөдөлмөр эрхлэлтийн дөрөвний нэг (24.5 хувь)-ийг бүрдүүлдэг хамгийн том салбар хэвээр байна.

**Зураг 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн**




Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо

Өмнөх оны мөн үеэс ажиллагчдын тоо өссөн салбарууд: бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ 26.4 мянгаар, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал 14.1 мянгаар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 10.5 мянгаар, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа 10.1 мянгаар, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ 5.9 мянгаар, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 5.2 мянгаар, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа 5.2 мянгаар, урлаг, үзвэр, тоглоом, наадам 4.8 мянгаар, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа 4.5 мянгаар, уул уурхай олборлолт 3.6 мянгаар, цахилгаан, хий, уур, агааржуулалт 3.0 мянгаар, барилга 2.4 мянгаар, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 0.6 мянгаар тус тус нэмэгджээ.

Харин өмнөх оны мөн үеэс ажиллагчдын тоо буурсан салбарууд: хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт 49.8 мянгаар, усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 3.6 мянгаар, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 3.5 мянгаар, боловсруулах үйлдвэрлэл 3.0 мянгаар, мэдээлэл холбоо 0.7 мянгаар, хүн хөлслэн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа 0.5 мянгаар, боловсрол 0.5 мянгаар, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа 0.4 мянгаар тус бүр буурсан байна.


**Зураг 4. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбар, өмнөх оны мөн үеэс, мянган хүн**



Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын тоог хүйсээр харвал өмнөх оны мөн үеэс хөдөө аж ахуйн салбарын эрэгтэй ажиллагчдын тоо 16.6 мянгаар, эмэгтэй ажиллагчдын тоо 33.4 мянгаар буурсан байна. Үйлдвэрлэлийн салбарт эрэгтэй ажиллагчдын тоо 0.2 мянгаар, эмэгтэй ажиллагчдын тоо 2.2 мянгаар нэмэгдсэн байна. Харин үйлчилгээний салбарт эмэгтэй ажиллагчдын тоо 51.4 мянгаар, эрэгтэй ажиллагчдын тоо 30.2 мянгаар өссөн байна.


**Зураг 5. Ажиллагчдын тооны өөрчлөлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 3 салбараар, хүйсээр, өмнөх оны мөн үеэс, мянган хүн**



Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын 624.2 мянга (45.9 хувь) нь Улаанбаатар хотод, 736.1 мянга (54.1 хувь) нь хөдөө, орон нутагт байна. Ажиллагчдыг бүсээр авч үзвэл 252.8 мянга (18.6 хувь) нь Хангайн бүсэд, 200.7 мянга (14.8 хувь) нь Төвийн бүсэд, 178.7 мянга (13.1 хувь) нь Баруун бүсэд, 104.0 мянга (7.6 хувь) нь Зүүн бүсэд байна. Ажиллагчдын тооны өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хот 62.1 мянгаар (11.1 хувь) өссөн бол Хангайн бүс 18.2 мянгаар (6.7 хувь), Төвийн бүс 7.0 мянгаар (3.4 хувь), Баруун бүс 2.7 мянгаар (1.5 хувь), Зүүн бүс 0.2 мянгаар (0.2 хувь) буурсан байна.

**Зураг 6. Ажиллагчдын тоо, байршлаар, бүсээр**



Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо


2024 оны III улирлын байдлаар ажилгүй иргэдийн 52.3 мянга (59.4 хувь) нь эрэгтэй, 35.7 мянга (40.6 хувь) нь эмэгтэйчүүд байна.

Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 14.2 мянга буюу 19.2 хувиар өсжээ. Үүнд ажилгүй эрэгтэйчүүд 9.1 мянга буюу 21.1 хувиар, эмэгтэйчүүд 5.0 мянга буюу 16.4 хувиар өссөн байна.

Ажилгүйчүүдийн тоог бүсээр авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 51.5 хувь нь, Хангайн бүсэд 15.7 хувь нь, Баруун бүсэд 13.8 хувь нь, Төвийн бүсэд 13.3 хувь нь, Зүүн бүсэд 5.7 хувь нь байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар 19.9 мянгаар, Баруун бүс 0.4 мянгаар өссөн бол Төвийн бүс 3.5 мянгаар, Хангайн бүс 2.5 мянгаар, Зүүн бүс 0.1 мянгаар ажилгүй иргэд буурчээ.

Мөн ажилгүйчүүдийн тоог насны бүлгээр авч үзвэл 21.2 мянга (24.1 хувь) нь 15-24 насны, 24.8 мянга (28.1 хувь) нь 25-34 насны, 22.0 мянга (25.0 хувь) нь 35-44 насны, 13.4 мянга (15.2 хувь) нь 45-54 насны, 6.7 мянга (7.6 хувь) нь 55, түүнээс дээш насны хүн байна. Ажилгүйчүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15-24 насны залуучууд 3.5 мянгаар, 25-34 насны залуучууд 4.7 мянгаар, 35-44 насны иргэд 0.8 мянгаар, 45-54 насны ажилгүй иргэд 2.3 мянгаар, 55 ба түүнээс дээш насны ажилгүй иргэд 2.8 мянгаар өссөн байна.

Зураг 7. Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 2. Ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн

Үзүүлэлт		2023				2024			Өөрчлөлт	
		I	II	III	IV	I	II	III	Он	Улирал
<b>Бүгд</b>		<b>87.2</b>	<b>76.2</b>	<b>73.9</b>	<b>53.3</b>	<b>71.8</b>	<b>82.3</b>	<b>88.1</b>	<b>14.2</b>	<b>5.8</b>
<b>Хүйсээр</b>	Эрэгтэй	53.9	46.6	43.2	34.4	41.4	47.6	35.7	-7.5	-11.9
	Эмэгтэй	33.2	29.6	30.7	18.9	30.3	34.7	52.3	21.6	17.6
	15-24	14.1	18.4	17.7	12.4	12.2	21.9	21.2	3.5	-0.7
<b>Насны бүлгээр</b>	25-34	25.3	20.8	20.1	14.2	22.1	21.9	24.8	4.7	2.9
	35-44	24.6	20.4	21.3	12.6	21.2	24.7	22.0	0.7	-2.7
	45-54	18.7	12.8	11	9.8	12.5	9.9	13.4	2.4	3.5
	55+	4.5	3.8	3.9	4.3	3.8	3.9	6.7	2.8	2.8
<b>Бүсээр</b>	Баруун бүс	11.6	13.7	11.7	6.7	13.1	12.3	12.1	0.4	-0.2
	Хангайн бүс	20.8	12.5	16.3	13.4	18.1	15.8	13.8	-2.5	-2.0
	Төвийн бүс	12.3	15.7	15.2	10.3	11.2	10.9	11.7	-3.5	0.8
	Зүүн бүс	3.5	3.1	5.1	3.7	4.4	3.9	5.0	-0.1	1.1
	Улаанбаатар	39	31.2	25.5	19.3	24.9	39.4	45.4	19.9	6.0

Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо

Ажилгүйчүүдийг боловсролын түвшнээр ангилбал 0.2 хувь нь магистр, 29.6 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 3.5 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 28.4 хувь нь техникийн болон мэргэжлийн, 26.4 хувь нь бүрэн дунд, 8.6 хувь нь суурь, 1.3 хувь нь бага, 2.1 хувь нь боловсролгүй иргэд байна.

Зураг 8. Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, хувиар

**3** хүн  
тутмын **1**


нь **Дипломын дээд болон бакалавраас дээш** боловсролтой байна.



Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо

Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 6.1 хувь болж, өмнөх улирлаас 0.3 пунктээр өмнөх оны мөн үеэс 0.8 пунктээр өссөн байна. Энэ хугацаанд эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 5.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр өссөн бол эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 6.6 хувь болж өмнөх оны мөн үеэс 1.0 пунктээр өссөн байна. Насны бүлгээр харвал 25-29 насны залуучууд 7.3 хувь буюу өмнөх улирлаас 2.6 хувиар өссөн бол 35-39 насны иргэд 5.1 хувь буюу 1.7 хувиар буурсан байна.

Зураг 9. Хөдөлмөрийн насны хүн ам (15+), хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувь, улирлаар




Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчний нийлүүлэлтийн эзлэх хувийг илэрхийлэх түвшин бүхий ажиллах хүчний оролцооны түвшинг улирлаар авч үзэхэд 2024 оны III улиралд 63.0 хувь болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.4 пунктээр, өмнөх улирлаас 0.8 пунктээр өссөн байна.

Хөдөлмөрийн нөөцөд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2024 оны III улирлын байдлаар 59.2 хувь болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.8 пунктээр өссөн байна.

**Зураг 10. Ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин**



Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2024 ОНЫ III УЛИРАЛ

## ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ ААНБ



## ТЭТГЭВЭР АВАГЧИД



## ШИМТГЭЛИЙН ОРЛОГО



## ДААТГУУЛАГЧ



## Даатгуулагчид, төрлөөр



## САЙН ДУРААР ДААТГУУЛАГЧ



## ЗАРЛАГА



Мэдээллийн эх үүсвэр: НДЕГ



### Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд

2024 оны III улирлын байдлаар шимтгэл төлөгч байгууллагын тоо 58.5 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.4 мянга буюу 4.4 хувиар өссөн байна.

Мөн 2024 оны III улирлын байдлаар нийгмийн даатгалд 1,209.5 мянган даатгуулагч даатгуулсан бөгөөд 153.9 мянга (12.7 хувь) нь сайн дурын, 1,055.6 мянга (87.3 хувь) нь албан журмын даатгуулагч байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 34.0 мянга буюу 2.9 хувиар өссөн байна.


Албан журмын даатгуулагч өмнөх оны мөн үеэс 22.3 мянга буюу 2.2 хувиар, сайн дурын дурын даатгуулагч 11.8 мянга буюу 8.3 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

### Хүснэгт 3. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллага, даатгуулагч, улирлаар

Улирал	Шимтгэл төлөгч ААНБ	Даатгуулагч		
		Нийт	Сайн дур	Албан журам
<b>2020 I</b>	42,862	831,943	108,042	723,901
II	46,762	961,692	156,624	805,068
III	47,818	1,051,309	172,892	878,417
<b>IV</b>	49,067	1,156,793	192,090	964,703
<b>2021 I</b>	46,242	845,802	100,956	744,846
II	48,738	962,387	136,141	826,246
III	50,625	1,062,030	147,827	914,203
<b>IV</b>	52,388	1,181,282	161,111	1,020,171
<b>2022 I</b>	48,462	891,825	107,417	784,354
II	51,776	1,029,922	133,167	896,755
III	53,425	1,141,946	146,833	995,113
<b>IV</b>	55,121	1,274,588	162,414	1,112,174
<b>2023 I</b>	51,282	925,215	108,644	816,571
II	54,405	1,061,097	129,881	931,216
III	56,057	1,175,543	142,159	1,033,384
<b>IV</b>	58,908	1,315,989	158,588	1,157,401
<b>2024 I</b>	49,329	860,181	56,135	804,046
II	53,075	927,414	94,686	832,728
III	<b>58,502</b>	<b>1,209,548</b>	<b>153,909</b>	<b>1,055,639</b>

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар


Зураг 11. Даатгуулагчийн тоо, төрөл, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Сайн дурын даатгуулагчдын 44.3 мянга (28.8 хувь) нь малчид, үлдсэн 109.6 мянга (71.2 хувь) нь бусад төрлийн даатгуулагч байна. Даатгалд хамрагдсан малчдын тоо өмнөх оны мөн үеэс 28.0 мянга буюу 2.7 дахин өссөн байна.

Зураг 12. Сайн дураар даатгуулсан малчдын тоо, мянган хүнээр, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд 2024 оны III улирлын байдлаар 503.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 15.5 мянга буюу 3.2 хувиар нэмэгджээ. Тэтгэвэр авсан иргэдийн 79.2 хувь нь өндөр насны тэтгэвэр, 12.5 хувь нь хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, 4.0 хувь нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 4.3 хувь цэргийн тэтгэвэр авсан байна.


Өндөр насны тэтгэвэр авсан иргэд 2024 оны III улирлын байдлаар 399.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 15.2 мянга буюу 4.0 хувиар, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авсан иргэд 20.1 мянга болж 174 буюу 0.9 хувиар, цэргийн тэтгэвэр авсан иргэд 21.6 мянга болж 380 буюу 1.8 хувиар өссөн бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авсан иргэд 63.0 мянга болж 215 буюу 0.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 4. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн тоо, төрөл, улирлаар

Улирал	Тэтгэвэр авагчдын тоо	Үүнээс:			
		Өндөр насны тэтгэвэр	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	Цэргийн тэтгэвэр
<b>2020 I</b>	427,247	320,602	67,912	19,853	18,880
II	434,186	327,799	67,663	19,711	19,013
III	439,481	333,026	67,769	19,584	19,102
IV	444,788	338,982	67,018	19,553	19,235
<b>2021 I</b>	449,419	344,287	66,344	19,511	19,277
II	451,845	347,235	65,771	19,377	19,462
III	454,298	350,091	65,197	19,437	19,573
IV	456,365	353,775	63,318	19,563	19,709
<b>2022 I</b>	462,607	359,783	63,439	19,588	19,797
II	467,420	364,173	63,491	19,625	20,131
III	471,387	368,050	63,280	19,705	20,424
IV	476,446	373,209	62,702	19,743	20,792
<b>2023 I</b>	480,312	376,643	63,097	19,744	20,828
II	484,981	380,843	63,133	19,850	21,155
III	488,366	384,043	63,117	19,969	21,237
IV	493,038	388,345	63,305	20,008	21,380
<b>2024 I</b>	496,669	391,819	63,302	20,079	21,469
II	500,560	395,387	63,412	20,107	21,654
III	<b>503,903</b>	<b>399,241</b>	<b>62,902</b>	<b>20,143</b>	<b>21,617</b>

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Зураг 13. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд, төрлөөр, хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэд 2024 оны III улирлын байдлаар 113.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 47.7 мянга буюу 29.6 хувиар буурсан байна. Тэтгэмж авсан иргэдийн 57.0 хувь нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, 33.6 хувь нь жирэмсний болон амаржсаны тэтгэмж, 9.3 хувь нь нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авсан байна.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авсан иргэд 2024 оны III улирлын байдлаар 64.5 мянга болж, өмнөх оны мөн үеэс 38.0 хувиар, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан иргэд 38.0 мянга болж өмнөх оны мөн үеэс 17.5 хувиар, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авсан иргэд 10.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар буурсан байна.

## Зураг 14. Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэдийн тоо, төрлөөр

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж



2023 III улирал

104 067

2024 III улирал

64 528



39 539 (38.0%)

Өмнөх оноос

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж



2023 III улирал

46 117

2024 III улирал

38 031



8 086 (17.5%)

Өмнөх оноос

Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж



2023 III улирал

10 597

2024 III улирал

10 566




31 (0.3%)

Өмнөх оноос


Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд 2024 оны III улирлын байдлаар 5.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 278 буюу 4.5 хувиар буурсан байна. ҮОМШӨ-ны даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэдийн 57.9 хувь нь хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, 20.3 хувь нь эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, 14.3 хувь нь тэтгэмж, төлбөрт, 7.5 хувь нь тэжээгчээ алдсаны тэтгэвэрт хамрагдсан байна.

## Зураг 15. ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд, төрлөөр, хувиар



- Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
- Тэтгэмж, төлбөр
- Эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2024 оны III улирлын байдлаар 3,086.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 657.0 тэрбум төгрөг буюу 27.1 хувиар, нийгмийн даатгалын зарлага 3,759.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 894.5 тэрбум төгрөг буюу 31.2 хувиар нэмэгдсэн.

2024 оны III улирлын байдлаар шимтгэлийн орлогын 82.7 хувийг тэтгэврийн даатгалын сан, 8.8 хувийг тэтгэмжийн даатгалын сан, 5.4 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, 3.1 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого бүрдүүлж байна. Харин нийгмийн даатгалын зарлагын 91.6 хувийг тэтгэврийн даатгалын сан, 4.9 хувийг тэтгэмжийн даатгал сан, 0.9 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, 2.6 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага эзэлж байна.

**Хүснэгт 5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр**

Үзүүлэлт	2023 III	Эзлэх хувь	2024 III	Эзлэх хувь	Өөрчлөлт	
					Тоо	Хувь
<b>НД-ын сангийн орлого</b>	<b>2,429.2</b>	<b>100.0%</b>	<b>3,086.2</b>	<b>100.0%</b>	<b>657.0</b>	<b>27.1%</b>
Тэтгэвэр	2,019.4	83.10%	2,552.7	82.7%	533.3	26.4%
Тэтгэмж	199.9	8.20%	270.6	8.8%	70.7	35.4%
ҮОМШӨ	171.1	7.00%	168.0	5.4%	-3.1	-1.8%
Ажилгүйдэл	38.8	1.60%	94.9	3.1%	56.1	144.6%
<b>НД-ын сангийн зарлага</b>	<b>2,865.0</b>	<b>100.0%</b>	<b>3,759.5</b>	<b>100.0%</b>	<b>894.5</b>	<b>31.2%</b>
Тэтгэвэр	2,602.8	90.80%	3,444.2	91.6%	841.5	32.3%
Тэтгэмж	154.2	5.40%	182.2	4.9%	28.0	18.1%
ҮОМШӨ	27.6	1.00%	34.1	0.9%	6.5	23.4%
Ажилгүйдэл	80.4	2.80%	99.0	2.6%	18.6	23.1%

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Ажилгүйдлийн тэтгэмжид 2024 оны III улирлын байдлаар 21.1 мянган иргэн хамрагдсан бөгөөд тэтгэмж болгож 99.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 2.0 мянга буюу 8.8 хувиар буурч, тэтгэмжид зарцуулсан хөрөнгө 18.6 тэрбум төгрөг буюу 23.1 хувиар нэмэгджээ.

2023 оны III улиралд ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан нэг хүнд дунджаар 3.5 сая төгрөгийг зарцуулж байсан бол 2024 оны III улиралд 4.7 сая болж, 34.9 хувиар нэмэгдсэн байна.

**Зураг 16. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, улирлаар**



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

## Сарын дундаж цалингийн үзүүлэлтүүд

Аж ахуй нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2024 оны III улирлын байдлаар 2,479.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 470.3 мянга буюу 23.4 хувиар, өмнөх улирлаас 14.7 мянга буюу 0.6 хувиар өссөн байна. Тухайн өсөлт нь нэрлэсэн дундаж цалингийн өсөлт бөгөөд бодит цалинийн өсөлт биш юм.

Ажиллагчдын сарын дундаж цалинг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүд 2,766.0 мянган төгрөг, эмэгтэйчүүд 2,158.4 мянган төгрөгийн цалинтай байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн цалингийн зөрүү 2024 оны III улиралд 580.6 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 43.1 мянгаар өссөн байна.

Өөрөөр хэлбэл 2024 оны III улирлын байдлаар эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийн дундаж цалингийн 79.0 хувьтай тэнцэж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.6 пунктээр өссөн нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цалингийн ялгаа энэ улирал өссөнийг харуулж байна.

### Хүснэгт 6. Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг

Үзүүлэлт	2023				2024			Өөрчлөлт	
	I	II	III	IV	I	II	III	Он	Улирал
Дундаж цалин	1,830.8	1,890.0	2,009.3	2,235.4	2,283.7	2,464.9	2,479.6	470.3	14.7
Эрэгтэй	2,044.2	2,096.4	2,275.4	2,479.8	2,568.4	2,716.7	2,766.0	490.6	49.3
Эмэгтэй	1,610.9	1,675.6	1,737.9	1,979.1	1,987.8	2,200.0	2,185.4	447.5	-14.6

Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо

Медиан цалин гэдэг ажиллагчдын цалинг өсөх эсвэл буурах эрэмбээр байршуулсан цувааг таллан хувааж байгаа ажилтны цалин юм. 2024 оны III улирлын байдлаар медиан цалин 2,024.3 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 467.9 мянган төгрөгөөр буюу 30.1 хувиар өссөн бол өмнөх улирлаас 2.7 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар буурсан байна.

2024 оны III улирлын байдлаар нийгмийн даатгалд шимтгэл төлсөн ажиллагчдыг цалин хөлсний бүлгээр авч үзвэл 420.0 мянгаас 700.0 мянган төгрөгийн цалинтай 9.9 хувь, харин 2.0 саяас 3.0 сая төгрөгийн цалинтай ажиллагчдын эзлэх хувь 26.0 хувь байна.

### Зураг 17. Дундаж болон медиан цалин, мянган төгрөг, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо

2024 оны III улирлын байдлаар 1-9 ажиллагчидтай байгууллагын дундаж цалин улсын дунджаас 1,014.3 мянгаар, 10-49 ажиллагчидтай байгууллагынх 392.7 мянгаар, 50-99 ажиллагчидтай байгууллагынх 138.9 мянгаар бага байгаа бол 100-199 ажиллагчидтай байгууллагынх 49.3 мянгаар, 200 түүнээс дээш ажиллагчидтай байгууллагынх 877.3 мянган төгрөгөөр өндөр байна.

Дундаж цалингийн өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд 200 дээш ажиллагчидтай байгууллагын ажиллагчдын дундаж цалин хамгийн их буюу 545.5 мянган төгрөг (19.4 хувиар)-өөр нэмэгдсэн байна.

**Хүснэгт 7. Ажиллагчдын сарын дундаж цалин, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр, мянган төгрөг**

Ажиллагчдын тооны бүлэг	2023 III			2024 III			Өөрчлөлт	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Тоо	Хувь
Бүгд	2,009.3	2,275.4	1,737.9	2,479.6	2,766.0	2,185.4	470.3	23.4%
1-9	1,178.6	1,180.5	1,176.7	1,465.3	1,463.4	1,467.2	286.7	24.3%
10-49	1,632.7	1,691.9	1,581.9	2,086.9	2,142.5	2,039.2	454.2	27.8%
50-99	1,821.1	1,999.4	1,660.8	2,340.7	2,546.5	2,168.8	519.6	28.5%
100-199	2,056.5	2,266.5	1,849.9	2,528.9	2,743.4	2,315.4	472.4	23.0%
200 дээш	2,811.4	3,269.9	2,208.3	3,356.9	3,832.4	2,701.8	545.5	19.4%

Мэдээллийн эх үүсвэр: [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзэхэд уул уурхай, олборлолтын салбарт ажиллагчдын цалин хамгийн их буюу 5.2 сая төгрөг, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт хамгийн бага буюу 1.6 сая төгрөг байна.

# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ-2024 ОНЫ III УЛИРАЛ

## АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН



7 178



## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН



5 811



## АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА



73 959



## АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭН




18 564



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ

## ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БҮЙ ГАДААДЫН ИРГЭД, улсаар

17 831 Гадаадын иргэд = 16 354 (91.7%) Эрэгтэй + 1 477 (8.3%) Эмэгтэй



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ



## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ

Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэдийн тоо 2024 оны III улирлын байдлаар 7.2 мянга (үүний 3.6 мянга буюу 49.9 хувь нь эмэгтэй) байна. Насны бүлгээр авч үзвэл, 0.8 мянга (10.7 хувь) нь 15-24 насны, 2.4 мянга (33.3 хувь) нь 25-34 насны, 2.3 мянга (31.4 хувь) нь 35-44 насны, 1.3 мянга (18.5 хувь) нь 45-54 насны, 0.4 мянга (6.1 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.


Харин тухайн үед ажилгүй байгаа, ажил идэвхтэй хайж хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн бүртгэлтэй ажилгүй иргэн 5.8 мянга байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 2.9 мянга (49.2 хувь) нь эрэгтэйчүүд, 3.0 мянга (50.8 хувь) нь эмэгтэйчүүд байна. Насны бүлгээр авч үзвэл, 0.6 мянга (11.0 хувь) нь 15-24 насны, 2.0 мянга (34.2 хувь) нь 25-34 насны, 1.8 мянга (31.6 хувь) нь 35-44 насны, 1.0 мянга (17.5 хувь) нь 45-54 насны, 0.3 мянга (5.7 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

### Хүснэгт 8. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар

Улирал	Ажил хайгч			Бүртгэлтэй ажилгүй иргэн		
	/сарын эцэст/	Эмэгтэй	Эзлэх хувь	/сарын эцэст/	Эмэгтэй	Эзлэх хувь
2020 I	31,785	16,285	51.2%	19,394	10,009	51.6%
II	30,320	15,367	50.7%	19,563	10,001	51.1%
III	<b>27,504</b>	<b>14,301</b>	<b>52.0%</b>	<b>17,829</b>	<b>9,446</b>	<b>53.0%</b>
IV	29,952	15,390	51.4%	18,103	9,535	52.7%
2021 I	25,105	12,774	50.9%	16,775	8,650	51.6%
II	26,991	13,837	51.3%	17,650	9,202	52.1%
III	<b>21,804</b>	<b>11,316</b>	<b>51.9%</b>	<b>15,053</b>	<b>7,895</b>	<b>52.4%</b>
IV	27,950	14,510	51.9%	18,644	9,821	52.7%
2022 I	24,255	12,019	49.6%	16,622	8,345	50.2%
II	24,184	12,075	49.9%	16,282	8,210	50.4%
III	<b>19,832</b>	<b>10,609</b>	<b>53.5%</b>	<b>13,545</b>	<b>7,389</b>	<b>54.8%</b>
IV	21,256	11,069	52.1%	13,966	7,326	52.4%
2023 I	14,246	7,238	50.7%	9,069	4,651	51.1%
II	5,737	2,954	51.5%	4,323	2,265	52.4%
III	<b>6,224</b>	<b>3,372</b>	<b>54.2%</b>	<b>4,655</b>	<b>2,568</b>	<b>55.2%</b>
IV	11,662	6,308	54.1%	8,813	4,784	54.3%
2024 I	6,896	3,303	47.9%	5,494	2,590	47.1%
II	9,563	4,384	45.8%	7,681	3,570	46.5%
III	<b>7,178</b>	<b>3,579</b>	<b>49.9%</b>	<b>5,811</b>	<b>2,954</b>	<b>50.8%</b>

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

**Зураг 18. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар**




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Ажил хайгч иргэдийн боловсролын түвшинг авч үзвэл, 1.2 хувь нь боловсролгүй, 4.5 хувь нь бага, 8.1 хувь нь суурь, 42.0 хувь нь бүрэн дунд, 7.0 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 30.9 дипломын дээд болон бакалавр, 2.3 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр авч үзвэл, 1.2 хувь нь боловсролгүй, 4.4 хувь нь бага, 7.6 хувь нь суурь, 40.2 хувь нь бүрэн дунд, 6.9 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.1 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 33.1 хувь нь дипломын дээд болон бакалавр, 2.5 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

**Зураг 19. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар**



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

2024 оны III улиралд 74.0 мянган ажлын байрны захиалга ирсэн бөгөөд 18.6 мянган иргэнийг ажилд зуучилж, эрэлтийн 25.1 хувийг хангажээ. Ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 23.7 мянга буюу 47.3 хувиар, ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 1.9 мянга буюу 11.5 хувиар нэмэгдсэн байна.

Ажилд зуучлагдсан иргэдийг насны бүлгээр авч үзвэл, 3.0 мянга (16.2 хувь) нь 15-24 насны, 5.2 мянга (28.1 хувь) нь 25-34 насны, 4.8 мянга (26.0 хувь) нь 35-44 насны, 3.6 мянга (19.2 хувь) нь 45-54 насны, 1.9 мянга (10.5 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

2024 оны III улиралд хөдөлмөрийн эрэлтийн 25.1 хувийг хангасан бөгөөд өмнөх оны мөн үеэс 8.1 пунктээр, өмнөх улирлаас 1.1 пунктээр буурсан байна.

**Хүснэгт 9. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн, улирлаар**

Улирал	Ажлын байрны захиалга	Ажилд зуучлагдсан иргэн	Эмэгтэй	Эзлэх хувь	Эрэлт хангасан хувь
2020 I	7,595	4,489	2,307	51.4%	59.1%
II	28,036	15,250	7,330	48.1%	54.4%
<b>III</b>	<b>42,433</b>	<b>21,672</b>	<b>10,858</b>	<b>50.1%</b>	<b>51.1%</b>
IV	58,022	33,006	16,651	50.4%	56.9%
2021 I	6,413	3,066	1,545	50.4%	47.8%
II	20,352	11,416	5,542	48.5%	56.1%
<b>III</b>	<b>32,656</b>	<b>17,636</b>	<b>9,068</b>	<b>51.4%</b>	<b>54.0%</b>
IV	51,034	29,929	15,460	51.7%	58.6%
2022 I	9,322	3,901	2,003	51.3%	41.8%
II	24,320	13,670	6,709	49.1%	56.2%
<b>III</b>	<b>32,972</b>	<b>18,897</b>	<b>9,499</b>	<b>50.3%</b>	<b>57.3%</b>
IV	55,211	32,290	16,412	50.8%	58.5%
2023 I	4,863	2,267	1,066	47.0%	46.6%
II	16,950	8,199	4,149	50.6%	48.3%
<b>III</b>	<b>50,222</b>	<b>16,656</b>	<b>8,660</b>	<b>51.2%</b>	<b>33.2%</b>
IV	84,870	35,281	18,903	53.6%	41.6%
2024 I	17,435	4,930	2,486	50.4%	28.3%
II	53,198	13,964	6,521	46.7%	26.2%
<b>III</b>	<b>73,959</b>	<b>18,564</b>	<b>8,976</b>	<b>48.4%</b>	<b>25.1%</b>

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 2024 оны III улиралд ирсэн ажлын байрны захиалгын 11.9 мянга нь боловсруулах үйлдвэрлэл (16.1 хувь), 10.3 мянга нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур (13.9 хувь), 9.5 мянга нь уул уурхай, олборлолт (12.8 хувь)-ын салбараас ирсэн байна.

2024 оны III улирлын байдлаар ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, урлаг, үзвэр, тоглоом наадам, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, боловсрол, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын 23.1-43.6 хувийг, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, уул уурхай, олборлолт, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, санхүүгийн болон даатгалын үйл

ажиллагаа, мэдээлэл, холбооны салбарын 15.7-34.5 хувийг, тээвэр, агуулахын үйл ажиллагаа, барилга, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа, цахилгаан, хий, уур, агааржуулалт, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын эрэлтийн 3.6-58.6 хувийг хангасан байна.

**Хүснэгт 10. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд**

Үзүүлэлт	Ажлын байрны захиалга	Ажилд зуучлагдсан иргэн		Эрэлт хангасан хувь
		Эзлэх хувь	Эзлэх хувь	
Бүгд	73,959	100.00%	18,564	25.1%
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	10,290	13.9%	3,553	34.5%
Уул уурхай, олборлолт	9,471	12.8%	1,686	17.8%
Боловсруулах үйлдвэрлэл	11,934	16.1%	2,612	21.9%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	278	0.4%	163	58.6%
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдал	4,938	6.7%	1,641	33.2%
Барилга	8,649	11.7%	804	9.3%
Бөөний болон жижиглэн худалдаа	5,745	7.8%	1,492	26.0%
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1,990	2.7%	408	20.5%
Зочид буудал, байр, нийтийн хоолны үйлчилгээ	1,956	2.6%	509	26.0%
Мэдээлэл, холбоо	400	0.5%	91	22.8%
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	343	0.5%	113	32.9%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	34	0.0%	4	11.8%
Мэргэжлийн ШУ болон техникийн үйл ажиллагаа	439	0.6%	81	18.5%
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	4,341	5.9%	683	15.7%
Төрийн удирдлага ба батлан хамгаалах	5,844	7.9%	2,218	38.0%
Боловсрол	3,179	4.3%	1,385	43.6%
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	2,143	2.9%	644	30.1%
Урлаг, үзвэр, тоглоом наадам	408	0.6%	102	25.0%
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1,439	1.9%	333	23.1%
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	110	0.1%	41	37.3%
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	28	0.0%	1	3.6%


Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

**Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадад ажиллах хүч зуучлах**

2024 оны III улирлын байдлаар хөдөлмөрийн гэрээгээр гадаадын 106 улсын 17,831 иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэд өмнөх оны мөн үеэс 5,608 буюу 45.9 хувиар, өмнөх улирлаас 2,222 буюу 14.2 хувиар нэмэгджээ. Гэрээгээр ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 16,354 (91.7 хувь) нь эрэгтэйчүүд, 1,477 (8.3 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 36.1 хувь нь Улаанбаатар хотод, 46.6 хувь нь Төвийн бүсэд, 12.3 хувь нь Зүүн бүсэд, 3.4 хувь нь Баруун бүсэд, 1.6 хувь нь Хангайн бүсэд оршин сууж байна.

Мөн хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийг иргэншлээр нь авч үзвэл, 12,364 (69.3 хувь) нь Хятад, 1,625 (9.1 хувь) нь Энэтхэг, 768 (4.3 хувь) нь Вьетнам, 415 (2.3 хувь) нь Турк, 393 (2.2 хувь) нь Филиппин, 330 (1.9 хувь) нь ОХУ, 288 (1.6 хувь) нь Өмнөд Солонгос, үлдсэн 1,648 (9.2 хувь) нь бусад улсын иргэн байна.

**Зураг 20. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, хамгийн их 6 улсаар, дүнд эзлэх хувиар**



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар



2024 оны III улирлын байдлаар 136 иргэн хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан бөгөөд өмнөх улирлаас 129 буюу 48.7 хувиар буурсан байна.

Гадаадад ажилд зуучлагдсан иргэдийн 92 (67.6 хувь) нь Өмнөд Солонгос, 44 (32.4 хувь) нь Япон улсад зуучлагдсан. Ажилд зуучлагдсан иргэдийн 71 (52.2 хувь) нь эрэгтэйчүүд, 65 (47.8 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл, 8.8 хувь 20-24 насны, 33.8 хувь нь 25-29 насны, 32.4 хувь нь 30-34 насны, 20.6 хувь нь 35-39 насны, 3.7 хувь нь 40-44 насны, үлдсэн 0.7 хувь нь 50-54 насныхан байна.


Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад зуучлагдсан иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 50.0 хувь нь бүрэн дунд, 38.3 хувь нь бакалаврын дээд, 6.6 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.4 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 0.7 хувь нь магистр, докторын боловсролтой байна.

Зураг 21. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд

■ БНСУ ■ Япон



**2** хүн  
тутмын **1**  
нь **25-34** насны  
иргэн байна.



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

## Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа

Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, ажил олгогч, залуучууд, эмэгтэйчүүд, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан зэрэг хөдөлмөрийн зах зээл дэх хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2024 онд улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндсэн 4 үйл ажиллагаа, 25 арга хэмжээг хэрэгжүүлж байна.

2024 оны III улирлын байдлаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 33.6 мянган иргэнийг хамруулж, 49.5 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийг үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 40.5 хувь нь Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа, 36.9 хувь нь Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа, 16.5 хувь нь Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 6.0 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан байна.

Зарцуулсан хөрөнгийг үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 77.0 хувь нь Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 12.3 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, 9.2 хувь нь Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа, 1.5 хувь нь Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Зураг 22. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, сая төгрөг, 2024 оны III улирлын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд 2024 оны III улирлын байдлаар 13.6 мянган иргэн хамрагдаж, 749.0 сая төгрөг зарцуулсан байна.

Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн 44.5 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт, 37.0 хувь нь суурь ур чадварын сургалт, 8.1 хувь нь танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт, 6.4 хувь нь залуучуудын сургалтын зөвлөгөө, 4.0 хувь нь эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтад хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 49.1 хувь нь танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт, 18.1 хувь нь суурь ур чадварын сургалт, 15.9 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт, 11.9 хувь нь эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалт, 5.0 хувь нь залуучуудын сургалт, зөвлөгөө зохион байгуулах арга хэмжээнд зарцуулсан байна.

Зураг 23. Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны III улирлын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөрт 2024 оны III улирлын байдлаар 5.6 мянган иргэн хамрагдаж, 38,095.1 сая төгрөг зарцуулсан байна.

Санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 46.7 хувь нь малчдыг малжуулах үйл ажиллагаанд, 24.2 хувь нь иргэн, аж ахуй эрхлэгчид санхүүгийн дэмжлэг, 19.2 хувь нь ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг, үлдсэн 9.9 хувь бусад арга хэмжээнд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 54.4 хувь нь малчдыг малжуулах арга хэмжээ, 27.3 хувь нь иргэн, аж ахуй нэгжийн санхүүгийн дэмжлэг, 16.7 хувь нь ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг, үлдсэн 1.6 хувь нь бусад үйл ажиллагаанд зарцуулагдсан байна.

## Зураг 24. Санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны III улирлын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2024 оны III улирлын байдлаар 2.0 мянган иргэн хамрагдаж, 6,083.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн 85.3 хувь нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 12.7 хувь нь хөдөлмөр эрхлэлтийн сургалт, 2.0 хувь нь бусад үйл ажиллагаанд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 81.9 хувь нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 14.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаа, 1.8 хувь нь ажил олгогчийг дэмжих үйл ажиллагаа, 1.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээ, 1.4 хувь нь бусад үйл ажиллагаанд зарцуулсан байна.



**Зураг 25. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, 2024 оны III улирлын байдлаар**



**2 016**


Хамрагдсан иргэд

**ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа**



**6 083.1** Сая төг

Зарцуулсан хөрөнгө



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Түр ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2024 оны III улирлын байдлаар 12.4 мянган иргэн хамрагдаж, 4,525.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Түр ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 79.0 хувь нь нийтийг хамарсан ажил зохион байгуулахад, 15.4 хувь нь мод тарих, 4.5 хувь нь ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд, 1.1 хувь нь хүүхэд хамгаалагч үйлчилгээнд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 70.7 хувь нь нийтийг хамарсан ажил зохион байгуулахад, 15.0 хувь нь мод тарихад, 12.2 хувь нь ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд, 2.1 хувь нь хүүхэд хамгаалагч үйлчилгээнд зарцуулсан байна.

**Зураг 26. Түр ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны III улирлын байдлаар**



**12 423**


Хамрагдсан иргэд

**Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа**



**4 525.7** Сая төг

Зарцуулсан хөрөнгө



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

## ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2024 ОН

### Судалгааны танилцуулга, зохион байгуулалт

Энэхүү судалгааны ажлыг “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны үзэл баримтлал /2023 он/” ын дата мэдээлэл буюу хоёрдогч мэдээлэл тулгуурлан гүйцэтгэсэн. Тухайн дата мэдээлэлд тоон болон чанарын судалгааны арга зүйг ашиглан тайланг боловсруулсан.

Судалгааг тухайн бүлгийн иргэдийн мэдээлэлд суурилсан байдлаар зохион байгуулж, өрхийн амьжиргааны түвшний оноо 409 ба түүнээс доош оноотой 87.1 мянган иргэнээс ахмад настан, залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэсэн гурван бүлгийн иргэдийн мэдээллийг нэгтгэн хамруулсан. Дээрх гурван бүлгийн хувьд ахмад настан /55-аас дээш настай эмэгтэй, 60-аас настай дээш эрэгтэй, хөгжлийн бэрхшээлгүй иргэд/, хөгжлийн бэрхшээлтэй иргэд /15-аас дээш насны иргэд/, залуучууд /15-34 насны хөгжлийн бэрхшээлгүй иргэд/ орно.

Улсын хэмжээнд зохион байгуулсан “Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаа”-нд 2023 оны 12 сарын дүнгээр 25.1 мянган өрхийн 133.4 мянган иргэн хамрагдсан. Судалгаанд хамрагдсан нийт өрхөөс “Өрхийн амьжиргааны түвшин”-ий оноо 409 болон түүнээс доош өрхийн ам бүлийн гишүүдийн судалгааны асуулгын дагуу ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээс холбогдох дата, тоон мэдээллийг нэгтгэсэн. Тус судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын зургаан дүүргийн зорилтот бүлгийн өрхийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон залуучууд гэсэн үндсэн гурван бүлэг тус бүрээс 10 иргэнийг сонгон нийт 30 иргэнийг R studio программ дээр санамсаргүй түүврийн аргаар сонгон авч фокус бүлгийн ярилцлагад хамруулав.

### Судалгааны хураангуй

Судалгааг тухайн зорилтот бүлгийн иргэдийн мэдээлэлд суурилан зохион байгуулж, өрхийн амьжиргааны түвшний оноо 409 ба түүнээс доош оноотой 16.2 мянган өрхийн 87.1 мянган иргэнээс ахмад настан, залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэсэн гурван бүлгийн иргэдийн мэдээллийг нэгтгэн хамруулсан.

Зорилтот бүлгийн өрхийн гишүүдийн 28.1 хувь нь 15-34 насны залуучууд, 6.8 хувь нь ХБИ, 5.1 хувь нь ахмад тус тус эзэлж байна.

**Хүн амзүйн төлөв байдал.** Судалгаанд хамрагдсан зорилтот бүлгийн ахмадуудын 26.9 хувь нь эрэгтэй, 73.1 хувь нь эмэгтэй байна. Улаанбаатар хотод хамгийн их нь оршин сууж байгаа бөгөөд зорилтот бүлгийн ахмадуудын 73.8 хувь нь эмэгтэй, 26.2 хувь нь эрэгтэй байна. Зорилтот бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 52.1 хувь нь эрэгтэй, 47.9 хувь нь эмэгтэй байна. Насны бүлгээр авч үзвэл 38.6 хувь нь 55+ насных Улаанбаатар хотод, 25.0 хувь нь 15-25 насных Хангайн бүсэд хамгийн их хамрагддаг байна. Судалгаанд хамрагдсан зорилтот бүлгийн 15-34 насны залуучуудын 47.8 хувь нь эрэгтэй, 52.2 хувь нь эмэгтэй байна. Байршлаар нь авч үзвэл 39.8 хувь нь Улаанбаатар хотод, 22.5 хувь нь Хангайн бүсэд хамгийн их суурьшиж байгаа нь харагдаж байна.

**Хөдөлмөр эрхлэлт.** Судалгаанд хамрагдсан зорилтот бүлгийн өрхийн нийт иргэдийн 33.4 хувь нь хөдөлмөр эрхэлдэг, 66.6 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй байна. Хүйсээр харвал нийт хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 47.1 хувь нь эмэгтэй, 52.9 хувь нь эрэгтэй байна. Нийт хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн 62.7 хувь нь цалинтай ажил, 18.5 хувь нь мал аж ахуй, 11.0 хувь нь бусад, 3.5 хувь нь цалин хөлсгүй ажил, 2.6 хувь нь өрхийн бизнес, газар тариалан, ажил олгогч гэсэн ангилалд орж байна. Бүс нутгаар харвал Улаанбаатар хотод 81.6 хувь нь цалинтай ажил, баруун бүсэд 9.2 хувь нь мал аж ахуй өндөр хувийн эзэлж байна.

Нийт хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг боловсролын түвшнээр авч үзвэл 47.8 хувь нь бүрэн дунд, 19.8 хувь нь суурь, 11.2 хувь нь бага, 9.0 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 6.2 хувь нь дээд, 6.0 хувь нь боловсролгүй байна.

**Төрөөс хэрэгжүүлдэг дэмжлэг үйлчилгээ.** Судалгаанд хамрагдсан нийт 87.1 мянган иргэдийн хувьд халамжийн үйлчилгээ тус бүрээр авч үзвэл давхардсан тоогоор 1.7 мянган нь тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэмж, 1.1 мянган нь ахмад настныг асарч байгаа иргэнд сар бүр олгох тэтгэмж, 2.4 мянган нь байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэнд сар бүр олгох тэтгэмж, 1.1 мянган нь байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдэд сар бүр олгох тэтгэмж, 1.0 мянган нь байнгын асаргаа шаардлагатай ахмад настанд улиралд нэг удаа олгох тэтгэмж, 15.0 мянган нь эхийн алдар 1,2-р зэргийн одон, 5.7 мянган нь 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, 1.6 мянган нь 0-18 хүртэлх насны 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-т улирал бүр олгодог, 3.1 мянган нь насны хишиг авдаг байна. Харин судалгаанд хамрагдсан нийт 16.2 мянган өрхийн 6.6 мянган өрх нь хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ авдаг байна.


### Судалгааны зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт

Зорилтот бүлгийн өрхийн хөдөлмөрийн насны нийт иргэдийн 33.4 хувь нь хөдөлмөр эрхэлдэг, 66.6 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй байна. Хүйсээр нийт хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 47.1 хувь нь эмэгтэй, 52.9 хувь нь эрэгтэй байна. Хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн 62.7 хувь нь цалинтай ажил, 18.5 хувь нь мал аж ахуй, 11.0 хувь нь бусад, 3.5 хувь нь цалин хөлсгүй ажил, 2.6 хувь нь өрхийн бизнес, газар тариалан, ажил олгогч гэсэн ангилалд орж байна. Бүс нутгаар харвал Улаанбаатар хотод 81.6 хувь нь цалинтай ажил, баруун бүсэд 9.2 хувь нь мал аж ахуй эрхлэлт өндөр хувийн эзэлж байна. Иргэдийг боловсролын түвшнээр авч үзвэл 47.8 хувь нь бүрэн дунд, 19.8 хувь нь суурь, 11.2 хувь нь бага, 9.0 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 6.2 хувь нь дээд, 6.0 хувь нь боловсролгүй байна.

### Ахмад настай иргэдийн хөдөлмөр эрхлэлт

Судалгаанд хамрагдсан ахмад настай иргэдийн 11.2 хувь нь сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхэлж, 88.8 хувь нь хөдөлмөр эрхлээгүй байна. Хөдөлмөр эрхэлж буй ахмадуудын 10.3 хувь нь эмэгтэй, 13.7 хувь нь эрэгтэй байна.

### Зураг 27. Ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийн ангилал, хувиар




Хөдөлмөр эрхэлдэг ахмадуудын 38.8 хувь нь цалинтай ажил, 37 хувь нь мал аж ахуй эрхэлж байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн бусад ангиллаар харьцуулбал өндөр байна.


## Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сүүлийн 7 хоногийн хөдөлмөр эрхлэлтийг авч үзвэл 12.7 хувь нь хөдөлмөр эрхэлдэг, 87.3 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй байна. Хөдөлмөр эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг 60.3 хувь нь эрэгтэй, 39.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 28. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн бэрхшээлийн төрөл, хувиар



Зураг 29. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт ангилал, хувиар




Хөдөлмөр эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн ангиллаар харьцуулбал 50.3 хувь нь цалинтай ажил, 28.1 хувь нь мал аж ахуй эрхлэлт байгаа нь өндөр хувийг бүрдүүлж байна.

## Залуучуудын /15-34 нас/ хөдөлмөр эрхлэлт

Зорилтот бүлгийн өрхийн 15-34 насны залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг авч үзвэл 30.5 хувь нь хөдөлмөр эрхэлсэн, 69.5 хувь нь хөдөлмөр эрхлээгүй байна. Хөдөлмөр эрхэлсэн залуучуудын 59 хувь нь эрэгтэй, 41 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 30. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр эрхлэлтийн ангилал, хувиар



Хөдөлмөр эрхэлдэг 15-34 насны залуучуудын 69.2 хувь нь цалинтай ажил, 13.3 хувь нь мал аж ахуй, 11.7 хувь нь бусад хөдөлмөр эрхлэлтийн ангилалд орж байгаа бөгөөд эдгээр хөдөлмөр эрхлэлтийн ангиллууд нь өндөр харагдаж байна.

## ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Хөдөлмөрийн насны хүн ам** гэж 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.

**Ажиллах хүч** гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.

**Ажиллах хүчнээс гадуурх хүн ам** гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас боломжит ажиллах хүчийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ.

**Хөдөлмөрийн дутуу ашиглалт** гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно.

**Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч** гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 5 өдрийн 40 цагаар авч үзнэ.

**Ажилгүй хүн** гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм.

**Боломжит ажиллах хүч** гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм.

**Ажиллах хүчний оролцооны түвшин:** Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{АХОТ} = \frac{\text{Ажиллах хүч}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

**Хөдөлмөр эрхлэлтийн түвшин:** Ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{ХЭТ} = \frac{\text{Ажиллагчдын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

**Даатгуулагч** гэж хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

**Нийгмийн даатгалын шимтгэл** гэж нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор иргэн болон төр, ажил олгогчоос нийгмийн даатгалын санд хуульд заасан хувь хэмжээгээр урьдчилан төлөх төлбөрийг хэлнэ.

**Ажилгүйдлийн тэтгэмж** гэж ажилгүй болохоосоо өмнө ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг хуульд заасан болзол, журмын дагуу төлсөн даатгуулагч ажилгүй болсон бол түүнд нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

**Дундаж цалин** гэж тайлант хугацаанд цалин, хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

**Нэрлэсэн цалин** гэдэг нь тодорхой хугацаанд хийсэн хөдөлмөрийнхөө төлөө авч буй мөнгөн төлбөрийн дүн юм.

**Ажил хайгч иргэн** гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

**Бүртгэлтэй ажилгүй иргэн** гэж хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

**Байнгын ажлын байр** гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил үүргийг;

**Байнгын ажилтан** нь байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг;

**Албан бус ажил олгогч** гэж тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг цалин хөлстэй ажиллагчаар ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхлэгч. Цаашид энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажил олгогч гэж нэрийднэ.

**Ажиллагч албан бус хөдөлмөр эрхлэгч** гэж хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч. Цаашид ажилтан энэ ангиллын албан бус хөдөлмөр эрхлэгчдийг ажилтан гэж нэрийднэ.

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хууль, 2021 он
2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хууль, 2011 он
3. Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, Үндэсний статистикийн хороо, 2019 он
4. Ажиллах хүчний судалгааны тайлан, Үндэсний статистикийн хороо, 2024 оны III улирал
5. Нийгмийн даатгалын хамрагдалт, тэтгэвэр, тэтгэмж авагчдын сарын мэдээ, Нийгмийн даатгалын ерөнхий газар
6. Ажил хайгч иргэний хөдөлгөөний сарын мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
7. Бүртгэлтэй ажилгүй иргэний хөдөлгөөний сарын мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
8. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэдийн мэдээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
9. Хөдөлмөрийн зах зээлийн тойм 2024 оны II улирал
10. Зорилтот бүлгийн өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа - 2024 он

### **АШИГЛАСАН ЦАХИМ ХУУДАС**

1. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
2. [www.1212.mn](http://www.1212.mn)
3. [www.mlsp.gov.mn/sp-dictionary](http://www.mlsp.gov.mn/sp-dictionary)
4. [www.ndaatgal.mn/v1/](http://www.ndaatgal.mn/v1/)
5. [www.hudulmur-halamj.gov.mn](http://www.hudulmur-halamj.gov.mn)





**REFERENCES**

1. Law on Labor of Mongolia, 2021
2. Law on Employment Promotion, 2011
3. Methodology for calculating employment statistics, National Statistics Office, 2019
4. Labor Force Survey Report, National Statistics Office, Quarter III 2024
5. Monthly information on social insurance coverage, pensions and benefits recipients, Social Insurance General Office
6. Monthly report on job seekers, General Agency for Labor and Welfare Service
7. Monthly report on registered unemployed civil movement, General Agency for Labor and Welfare Service
8. Job orders, job placement information, General Agency for Labor and Welfare Service
9. Labor Market Bulletin-Quarter II 2024
10. Survey on the employment of target households' members, 2024

**WEBSITES**

1. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
2. [www.nso.mn](http://www.nso.mn)
3. [www.1212.mn](http://www.1212.mn)
4. [www.misp.gov.mn/sp-dictionary](http://www.misp.gov.mn/sp-dictionary)
5. [www.ndaatgal.mn/v1/](http://www.ndaatgal.mn/v1/)
6. [www.hudulmur-halamj.gov.mn](http://www.hudulmur-halamj.gov.mn)

**Job seekers** is a person who is unemployed or employed but looking to improve conditions of employment and additional income.

**Registered unemployed** are those, not employed or not own account workers, available to work, actively seeking job, at working age and registered in labor and welfare service offices or private labor exchange.

**Permanent job** duties which are undertaken at employer's workplace on work days or in shifts using the employer's work tools pursuant to a pre-determined procedure under the norm, evaluation and salary rate approved under the employer or its representative's supervision.

**Permanent worker** is a person who holds a permanent job under formal employment agreement and whose taxes and social insurance are paid by the employer and labor relations are regulated by laws on labor and public service.

**Informal employer** A self-employed person who employs one or more persons for a fixed period of time as a "paid employee". Henceforth, this category of informal employment workers will be referred to as "employer".

**Informal employee** A paid employee working in conditions where the employment relationship is not fully regulated within the legal framework. From now on, this category of informal employment workers will be referred to as "employee".

## TERMS AND DEFINITIONS

**Working age population** is defined as those aged 15 years and above. Working age population is categorized into labor force and persons outside of the labor force.

**Labor force** refers to the current supply of the labor for the production of goods and services in exchange for pay or profit.

**Persons outside the labor force** are those of working age who were neither in employment nor in unemployment in the short reference period with reasons of either in education, retired, elderly and disability or were discouraged for seeking employment. Extended labor force is defined as the sum of the labor-force and the potential labor force.

**Labor underutilization** refers to mismatches between labor supply and demand, which translates to an unmet need for employment among the working age population.

**Persons in time-related underemployment** are defined as all persons in employment who, during a short reference period, wanted to work additional hours or whose working time in all jobs was less than a specified hours threshold. Moreover, those who were available to work additional hours given an opportunity for more work. The specified hours threshold is determined in Mongolia labor law currently as 40 hours in a week.

**Persons in unemployment** are defined as all those of working age who were not in employment, carried out activities to seek employment during a specified recent period and were currently available to take up employment given a job opportunity.

**Potential labor force**, refers to persons not in employment who express an interest in this form of work but for whom existing conditions limit their active job search and/or their availability.

**Labor force participation rate**: Shall be figured by the ratio of number of labor force and working age population.

$$\text{Labour force participation rate} = \text{Number of labour force} / \text{Number of working-age population} * 100\%$$

**Employment-to-population ratio**: Shall be estimated by the ratio of the number of employed to number of working age population.

$$\text{Employment to population ratio} = \text{Number of employed} / \text{Working-age population} * 100\%$$

**Insured** means a person and legal entities whose social insurance premiums are paid and interests are protected by an insurance policy and who contracts for an insurance policy that indemnifies him or her against loss of job, property, life or health etc.;

**Social insurance premium** is an advance payment made by an individual, the state or an employer to the social insurance fund at the rate specified by law for the purpose of social insurance.

**Unemployment allowance** is an amount of money to be paid from the social insurance fund to an insured person who has paid unemployment insurance premiums before becoming unemployed in accordance with the conditions and procedures set forth in the law.

**Average salary** is calculated by dividing total amount of received salary by total number of worked month.

**Nominal salary** is the rate of pay employees are compensated for the work performed during a given period.

69.2% of employed young people have paid jobs, 13.3% are in animal husbandry, and 11.7% are in other occupations, which represent the highest category.



Figure 30. Youth employment, by employment category /percent/

30.5 percent of young people aged 15-34 from the target group households are employed, while 69.5 percent are unemployed. Of the employed young people, 59 percent are men and 41 percent are women.

**Employment of youth /aged 15-34/**

By employment category, 50.3 percent of employed people with disabilities are in paid jobs, and 28.1 percent are in animal husbandry, which constitutes the majority.




Figure 29. Employment of people with disabilities, by category /percent/




Figure 28. Employment of people with disabilities, by type of disability /percent/

In the past week, 12.7 percent of people with disabilities were employed, while 87.3 percent were unemployed. Of those employed, 60.3 percent were men and 39.7 percent were women.

**Employment of the people with disabilities**

Among the employed elderly, 38.8 percent are in paid jobs and 37 percent are engaged in animal husbandry, both of which are higher than those in other categories of employment.




Figure 27. Category of the elderly employment /percent

Out of the total elderly population covered by the survey, 11.2 percent were employed, while 88.8 percent were not employed in the past week. Among the employed elderly, 10.3 percent were women, and 13.7 percent were men.

### Employment of the elderly

By education level, 47.8 percent of the total employed have upper secondary education, 19.8 percent have lower secondary education, 11.2 percent have primary education, 9.0 percent have technical and vocational education, 6.2 percent have higher education, and 6.0 percent have no education.

33.4 percent of total working-age people from the target group are employed, while 66.4 percent are unemployed. By gender, 47.1 percent of total employed are women, while 52.9 percent are men. Of the total employed people, 62.7 percent are in paid jobs, 18.5 percent are in animal husbandry, 11.0 percent are in other occupations, 3.5 percent are in unpaid jobs, and 2.6 percent are in family businesses, farming, or are employers. By region, Ulaanbaatar has a high percentage of paid employment at 81.6 percent, while the Western region has a high percentage of livestock farming at 92.2 percent.

### Employment of people from the target group of the survey

Government-provided support services. By types of social welfare services provided to a total of 87.1 thousand people covered by the survey, 1.7 thousand (by double counting) received survivor's benefits for children up to 18 years old, 1.1 thousand received the monthly benefit for elderly caregivers, 2.4 thousand received the monthly benefit for caregivers of persons with disabilities requiring permanent care, 1.1 thousand received the monthly benefit for children up to 16 years old requiring permanent care, 1.0 thousand received the quarterly benefit for elderly individuals requiring permanent care, 15.0 thousand received the cash allowance for the "First and Second Order of Glorious Motherhood," 5.7 thousand received the benefit for looking after a child aged 0-3, 1.6 thousand received the quarterly benefit for single parents with three or more children aged 0-18, and 3.1 thousand received the old-age benefit. Out of the total 16.2 thousand beneficiaries covered by the survey, 6.6 thousand received food support services.

**SURVEY ON THE EMPLOYMENT OF TARGET HOUSEHOLDS' MEMBERS-2024**

**Survey introduction and organization**

This survey has been carried out based on the data from the 'Research Concept for Determining the Standard of Living of Households Using the Income Substitution Method /2023/' or secondary data. The report has been written using quantitative and qualitative research methods based on the data.

The survey has been organized based on data from the target population, including groups such as the elderly, youth, and people with disabilities. Out of data from 87.1 thousand people living standard score of 409 or above, the data from the aforementioned three groups of people have been compiled and used for the survey. The three groups mentioned above include the elderly (women over 55 years old, men over 60 years old, and people without disabilities), people with disabilities (those over 15 years old), and young people (individuals without disabilities aged 15-34 years old).

As of December 2023, a total of 133.4 thousand people from 25.1 thousand households participated in the nationwide 'Survey on Determining Household Living Standards'. Necessary information and data among the comprehensive data of members from households with 409 or lower score of households living standard provided according to the survey questionnaire has been compiled for the survey. A total of 30 participants, 10 from each target group (the elderly, youth, and people with disabilities) across six districts of Ulaanbaatar city, were selected using a random sampling method in the R Studio program and participated in a focus group interview.

**Survey overview**

The survey has been organized based on data from the target population, including groups such as the elderly, youth, and people with disabilities. Out of data from 87.1 thousand people from 16.2 thousand households with a living standard score of 409 or above, the data from the aforementioned three groups of people have been compiled and used for the survey.

28.1 percent of the members of target households are young people aged 15-34, 6.8 percent are people with disabilities, and 5.1 percent are elderly people.

**State of demography.** 26.9 percent of the elderly people covered by the survey are men, and 73.1 percent are women. Most of them live in Ulaanbaatar, where 73.8 percent of the elderly target group are women and 26.2 percent are men. Among the people with disabilities in the target group, 52.1 percent are men and 47.9 percent are women. By age group, 38.6 percent of those aged 55 and older are in Ulaanbaatar, and 25.0 percent of those aged 15-25 are in the Khangai region. Among people aged 15-34 covered by the survey, 47.8 percent are men, and 52.2 percent are women. By region, 39.8 percent are in Ulaanbaatar and 22.5 percent are in the Khangai region.

**Employment.** Among the total people from target group households covered by the survey, 33.4 percent are employed, while 66.6 percent are unemployed. By gender, 47.1 percent of the total employed are women and 52.9 percent are men. Of the total employed people, 62.7 percent are in paid jobs, 18.5 percent are in animal husbandry, 1.0 percent are in other occupations, 3.5 percent are in unpaid jobs, and 2.6 percent are in family businesses, farming, or are employers. By region, Ulaanbaatar has a high percentage of paid employment at 81.6 percent, while the Western region has a high percentage of livestock farming at 9.2 percent.

By education level, 47.8 percent of the total employed have upper secondary education, 19.8 percent have lower secondary education, 11.2 percent have primary education, 9.0 percent have technical and vocational education, 6.2 percent have higher education, and 6.0 percent have no education.



2 016  
Participants




Figure 25: People who participated in the Employment Promotion Program for Persons with Disabilities, expenditure spent on the program, as of Quarter III 2024

As of the third quarter of 2024, 2,016 people participated in the Employment Promotion Program for Persons with Disabilities and MNT 6,083.1 million spent on the program.

Within the program, 85.3 percent of participants attended the employment promotion program, 12.7 percent attended employment training, and 2.0 percent received other services. In terms of expenditure, 81.9 percent of the total expenditure was allocated to financial support, 14.0 percent to other employment promotion services for persons with disabilities, 1.0 percent to employment promotion complex service for persons with disabilities, and 1.4 percent to other services.



12 423  
Participants



Figure 26: People who participated in Temporary Job Promotion Program, expenditure spent on the program, as of Quarter III 2024


As of the third quarter of 2024, 12,423 people participated in the Temporary Job Promotion Program, with MNT 4,525.7 million spent on the program.

Within the program, 79.0 percent of participants were involved in public work, 15.4 percent in tree plantation activities, 4.5 percent received consultancy services from senior professionals, and 1.1 percent received child protection services. In terms of expenditure, 70.7 percent of the total expenditure was allocated to organizing public work, 15.0 percent to organizing tree plantation activities, 12.2 percent to the consultancy services from senior professionals and, 2.1 percent to child protection services.

Source: General Agency of Labor and Welfare Service

Source: General Agency of Labor and Welfare


Figure 23. People who participated in the Employment Preparation Program, expenditure spent on the program, as of Quarter III 2024



As of the third quarter of 2024, 5,565 people participated in the Financial Support Program, with MNT 38,095.1 million spent on the program.

Within the program, 46.7 percent of participants received service for reconstitution of herds among herders, 24.2 percent received financial support for individuals and entities, 19.2 percent received financial support for the employment of senior citizens, and 9.9 percent received other services. In terms of expenditure, 54.4 percent of the total expenditure was allocated to the service for reconstitution of herds among herders, 27.3 percent to the financial support for individuals and entities, 16.7 percent to the financial support for the employment of senior citizens and 1.6 percent to other services.

Figure 24. People who participated in the Financial Support Program, expenditure spent on the program, as of Quarter III 2024



Source: General Agency of Labor and Welfare Service



**Employment promotion programs**


The MLSF develops policies in the field of employment and oversees the implementation of employment promotion programs for different target groups of population such as unemployed, people facing difficulty in finding jobs, employers, youth, women, herders, people with disabilities and elderly. In this regard, 25 measures of 4 employment promotion programs are being implemented nationwide in 2024.

As of the third quarter of 2024, a total of 33,635 people participated in employment promotion programs and MNT 49.5 billion were spent on the employment promotion programs.

By type of programs, 40.5 percent of total participants were involved in Employment Preparation Program, 36.9 percent in Temporary Job Promotion Program and 16.5 percent in Financial Support Program, and 6.0 percent in Employment Promotion Program for Persons with Disabilities.

By type of programs, 77.0 percent of total expenditure was spent on the Financial Support Program, 12.3 percent on the Employment Promotion Program for Persons with Disabilities, 9.2 percent on the Temporary Job Promotion Program, and 1.5 percent on the Employment Preparation Program.


**Figure 22. People who participated in the employment promotion programs, the expenditure spent on the programs, MNT million, as of Quarter III 2024**



As of the third quarter of 2024, 13,635 people participated in the Employment Preparation Program and MNT 749.0 million were spent on the program.

Within the program, 44.5 percent of total participants attended an entrepreneurship training, 37.0 percent attended a basic skills training, 8.1 percent the classroom and field training, 6.4 percent attended a training and consultancy for the youth, and 4.0 percent attended the short-term skills training for women. In terms of the expenditure, 49.1 percent of total expenditure was spent on the classroom and field training, 18.1 percent on the basic skills training, 15.9 percent on entrepreneurship training, 11.9 percent on the short-term skills training for women and 5.0 percent on the training and consultancy for youth.

Figure 20. Foreign citizens working in Mongolia under labor contract, by percentage number of employees, by percentage




Source: General Agency of Labor and Welfare Service

In the third quarter of 2024, 136 people were placed in job abroad under the labor contract and the number of people placed in job under the labor contract decreased by 129 or 48.7 percent compared to the previous quarter.

Out of total people who were placed in job abroad, 92 (67.6 percent) were placed in employment in South Korea and 44 (32.4 percent) were placed in jobs in Japan. Out of total people who were placed in jobs, 71 (52.2 percent) are men and 65 (47.8 percent) are women. By age group, 8.8 percent are the people aged 20-24, 33.8 percent are the people aged 25-29, 32.4 percent are the people aged 30-34, 20.6 percent are the people aged 35-39, 3.7 percent are the people aged 40-44 and 0.7 percent are the people aged 50-54.

By education level, 50.0 percent have upper secondary education, 38.3 percent have bachelor degree or diploma, 6.6 percent have technical and vocational education, 4.4 percent have specialized secondary education, and 0.7 percent have master's and postgraduate education.

Figure 21. People who were placed in job abroad under the labor contract



services; wholesale and retail trade, repair of vehicles and motorcycles; manufacturing; financial and insurance activities; and information and communication, and 3.6-58.6 percent in transportation and storage; construction; and information of extraterritorial organizations and bodies; electricity, gas, steam and air conditioning supply; and real estate activities.

Table 10. Job order, job placement

Sector of economic activities	Job order	Percentage	Job placement	Percentage	Demand fulfillment percentage	
					Percentage	Percentage
Total	73,959	100.0%	18,564	100.0%	25.1%	
Agriculture, forestry, fishing and hunting	10,290	13.9%	3,553	19.14%	34.5%	
Mining and quarrying	9,471	12.8%	1,686	9.08%	17.8%	
Manufacturing	11,934	16.1%	2,612	14.07%	21.9%	
Electricity, gas, steam and air conditioning supply	278	0.4%	163	0.88%	58.6%	
Water supply, sewerage, waste management and remediation activities	4,938	6.7%	1,641	8.84%	33.2%	
Construction	8,649	11.7%	804	4.33%	9.3%	
Wholesale and retail trade	5,745	7.8%	1,492	8.04%	26.0%	
Transportation and storage	1,990	2.7%	408	2.20%	20.5%	
Hotel, accommodation and food service activities	1,956	2.6%	509	2.74%	26.0%	
Information and communication	400	0.5%	91	0.49%	22.8%	
Financial and insurance activities	343	0.5%	113	0.61%	32.9%	
Real estate activities	34	0.0%	4	0.02%	11.8%	
